



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№86 /530/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.05.26



Төгсөгчдөдөө 20 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлэе!

МЭНДЧИЛЭЭ



КУРСЫН ЗӨВЛӨХ БАГШ, АНАГААХЫН УХААНЫ ДОКТОР Н.МЭНТЭВДОРЖ

2003 оны төгсөгчдөдөө 20 жилийн ойн баярын мэндийг хүргэе. Цаг хугацаа нисэн өнгөрч Та бид бүхэн хэдийнээ 20 жилийг ардаа орхижээ. 20 жилийн өмнөх яг энэ үед та бүгд минь сургуулиа төгсөж ромбо дипломоо гардан авч шинэхэн эмч нар болж байсан. Үүний зэрэгцээ сургуульдаа юу үлдээх талаар хэд хэдэн удаа хуралдаж сургуулийн үүдийг зурганд буулган зурж үлдээж байсан.

Тэгвэл одоо та нар туршлагатай эмч нар болж эх орны хэрэгцээт газруудад ажиллаж байна. Та нар дотор сургуулийн тэргүүн дэд захирал, Био анагаахын сургуулийн захирал, хэд хэдэн тэнхимийн эрхлэгч мөн Улсын нэгдсэн эмнэлгийн захирал, Дүүргийн эмнэлгийн захирал, Эрүүл мэндийн яамны ажилтан, мэргэжилтэн, газар, хэлтсийн дарга зэрэг албан тушаалыг хашиж буй эрхмүүд байна.

Мөн түүнчлэн 30 гаруй доктор, профессор, дэд профессор, клиникийн профессорууд төрөн гарчээ. Ингээд олон зүйлсийг эс нуршин энэ нийгмийн гэрэл гэгээ нь болсон шавь нартаа ажилд нь амжилт, амьдралд нь хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.



БИД НЭГ ҮЕИЙНХЭН



Өнөөдрөөс хорин жилийн өмнө Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургуулийн хүний их эмч бэлтгэх хөтөлбөрийг дүүргэж, эх орныхоо өнцөг булан бүрд 187 эмч мэргэжилтэн, ажлын гараагаа эхэлж байсны 20 жилийн ой энэ 2023 онд тохиож байна.

Тэгвэл уг тэмдэглэлт өдрийг тохиолдуулан ЭМШИУС-ийн анхны төгсөгчдийн "Алтангагнуур-2023" дурсамж уулзалтыг зохион байгуулж байна. Уулзалтад ЭМШИУС-ийн үе үеийн төгсөгчид, багш, ажилтнууд болон тэдний ирээдүй хойч үе, залгамж халаа болсон оюутан залуусын төлөөлөл оролцлоо.

Арга хэмжээний хүрээнд Монгол Улсын ардын багш, гавьяат багш, доктор, профессор А.Гүрбадам, Монгол Улсын ардын багш, доктор, профессор Г.Батбаатар, Монгол Улсын гавьяат эмч, доктор, профессор Л.Мөнгөнцэцэг, Монгол Улсын гавьяат эмч, төрийн соёрхолт, клиникийн профессор С.Эрдэнэ, Монгол Улсын гавьяат эмч, клиникийн профессор А.Эрдэнэбилэг, Монгол Улсын гавьяат эмч, доктор Н.Баясгалан, Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, доктор, профессор Н.Хүрэлбаатар, Доктор, профессор С.Сээсрэгдорж, доктор, дэд профессор Б.Баясгалан, доктор, профессор О.Чимэдсүрэн, Анагаах ухааны доктор, дэд профессор Н.Мэнтэвдорж нарт хүрэлцэн ирсэн зочид, төлөөлөгч болон төгсөгчид хүндэтгэл үзүүллээ.

Мөн энэ үеэр шилдэг эмчээр М.Зоригтбаатар, С.Нэргүй, шилдэг судлаачаар Л.Энхсайхан, шилдэг эм зүйчээр Ү.Отгонбаатар, нүүр ам судлалын шилдэг эмчээр Ж.Эрдэнэцогт, уламжлалт анагаахын шилдэг эмчээр Б.Буджаргал, шилдэг эрүүл ахуйч, тархвар судлаачаар Ц.Жавзандулам, орон нутагт ажиллаж буй шилдэг төгсөгчөөр С.Булгамаа, гадаадад ажиллаж буй шилдэг төгсөгчөөр Б.Бадамханд нарыг тус тус нэрлэж 2003 оны шилдгээр төгсөгчөөр тодруулан өргөмжлөл, дурсгалын зүйлийг гардуулсан юм.



ЭМШУИС-ИЙН 2003 ОНЫ ТӨГСӨГЧИД

УЛАМЖЛАЛТ АНАГААХЫН СУРГУУЛЬ

Арван жилийн сургуулиа төгсөж, сурагчийн ширээнээс дөнгөж холдсон хүүхдүүд газар газраас цуглаж 1997 оны намар нэгэн анги хамт олон болж байв. Анагаах ухааны А үсэг ч үгүй бид анатоми, физиологи, дорно дахины анагаах ухааны түүх, эх сурвалж, Төвөд хэл гээд л янз бүрийн хичээлд шамдан суралцаж, асуугдахдаа асуугдаж, загнуулахдаа загнуулж, дуулахдаа дуулж, инээхдээ инээж хамтдаа туулсан 6 жил харвасан сум шиг өнгөрч 2003 оны хавар 24-үүлээ сургуулиа төгсөж билээ.

Нэгэн хөгжилтэй дурсамж сөхвөл нэгдүгээр курст гистологийн хичээл дээр Цолмон багш бичил препаратаар шүүлэг авч дуусаад, асуугдаагүй хүн байна уу гэхэд Өмнөговийн шавилхан охин "Багш аа, би таагаагүй" гэж билээ. Цолмон багш нүд нь гурвалжилж дөрвөлжилж ирээд "Би та нараар ямар оньсого таалгаа юу?" гэж уурсан, бид хэд наана нь доош харан жуумалзаж өнгөрч байсан сан. Бидэнд энэ мэт хөгтэй, хөөртэй дурсамжууд олон бий.

Одоо бүгд л амьдралын жамаар бүл зохиож, эмчийн сайхан мэргэжлээ эрхэмлэн ахиулан суралцаж, төрөлх сургуульдаа багш, эмнэлгийн орлогч дарга, хувийн эмнэлгийн захирал, Авлигатай тэмцэх газрын комиссар, аймгийн НЭ-ийн тасгийн эрхлэгч, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, төрийн тусгай алба, төр болон хувийн хэвшлийн эмнэлэгт эх барих эмэгтэйчүүдийн эмч, мэдрэлийн эмч, сэргээн засахын эмч, уламжлалтын эмчээр тус тус ажиллаж



Манай ангийн хэсэг нөхөд 2-р курстээ хичээлийн үеэр

байна. Мөн түүнчлэн манай ангиас Анагаах ухааны доктор 2, магистр 10, ЭХТА 20, Алтангадас одонт 2, Хөдөлмөрийн хүндэт медальтан 5, Энхийг сахиулагч "Энхийн төлөө" медальтан, Онц хилчин, "Алдарт эх" чүүд төрөн гарчээ. Энэ мэт үргэлжлүүлэн яривал бидэнд дундаршгүй их дурсамж, дурдатгал бий. Ингээд олон зүйлсийг эс нурушин эрүүл энхийн төлөөх ариун үйлсэд чин сэтгэлээр цуцалтгүй зүтгэж,

дэлхийн анагаах ухааны хөгжлийг эх орондоо авчрах, бусдадаа үлгэр дуурайл үзүүлэх, нийгмийн амьдралд идэвхтэй иргэн байх үүрэг хариуцлагаа нэр төртэйгөөр биелүүлж, эх орныхоо өнцөг булан бүрд хүн ардынхаа эрүүл энхийн ээлжгүй манаанд хичээн зүтгэж байгаа АШУУИС-ийн үе үеийн төгсөгчдийн жил бүр хүсэн хүлээдэг "Алтангагнуур" чуулга уулзалтад хүрэлцэн ирсэн та бүгддээ ажилд нь амжилт, амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

ЭМ ЗҮЙН СУРГУУЛЬ

501-р хэсгийн төгсөгч Л.Ундрахмөрөн:

"Юуны өмнө эм зүйн ангиа төлөөлөн ярилцлага өгч байгаадаа баяртай байна. 2003 оны нийт төгсөгчдөө 20 жилийн ойн баярын мэнд хүргэе. Манай анги оюутан цагаасаа эхлэн салбартаа манлайлагч байсаар ирсэн. Тухайлбал, Анагаахын сургуулийн нэг ангиас түүн дотроо нэг группээс дөрвөн оюутан "Онцгойлох диплом"-той төгссөн түүх ховор билээ. Өдгөө гэхэд манай ангиас гурван доктор, гурван докторант, 13 магистр төрөн гарч эм зүйн салбараа түүчээлж явна. Жишээ дурдвал доктор Э.Сарнайзул Ph.D, Ч.Мөнх Амгалан Ph.D, Ү.Отгонбаатар Ph.D, докторант С.Оюунбилэг /ХБНГУ/, Б.Хулан, С.Уянга нар маань эрдэм шинжилгээ судалгааны ажлаараа бусдыгаа манлайлан төрийн болон хувийн хэвшлийн салбаруудад амжилттай ажиллаж байна. Мөн ангийн найзууд маань Нэгдүгээр шатлалын эмнэлэг, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, ЭЭХХЗГ, Эм хангамжийн байгууллага, АШУУИС-д багш, Эмч төлөөлөгчийн газар, Эм үйлдвэрлэлийн салбар, Эмийн сан, Санхүү эдийн засаг зэрэг эм зүйн тусламж үйлчилгээ шаардагддаг бүхий л газарт мэргэжлийн үнэ цэнээ өндөрт өргөн ажилласаар байна.

Бидний оюутан ахуй цаг мартагдсан аргагүй дурсамжтай, хөгжөөнтэй, адал явдал, баяр хөөрөөр дүүрэн өнгөрсөн. Жишээ дурдвал Эм зүйн ангийнхан хоёр ба гуравдугаар курс төгсөхдөө ургамлын зуны



дадлагад явдаг бөгөөд тэр чигээрээ адал явдалтай кино шиг өнгөрдөг байв. Хоёрдугаар курсийн дадлагын үеэр манай ангийн Сарнайгийн аав нь эргэлтээр ирээд охиноо хайж замд тааралдсан хүнээс Анагаахын дадлага хийж байгаа оюутнуудыг сураг гаргатай нөгөө хүн нь тэр дээр байгаа хогон дээр гэсэн байдаг /инээв/. Гэтэл яг үнэндээ хогон дээр байгаагүй л дээ.

Бас нэг удаа Нараян маань халат аа мартчихсан. Тэгтэл латин хэлний Баянбилэг багш (тухайн үед бид нарын маш их айдаг байсан багш нарын нэг) хичээл орохоор болов. Тэгээд мань хүн

айсандаа болоод сургуулийн коридорт цэвэрлэгээ хийж байсан цэвэрлэгч эгчээс халатыг нь гуйгаад өмсчихсөн юм. Нөгөө халат нь жижигдэж барьсан тул туйлын инээдтэй харагдаж байлаа. Тухайн үед ангиараа инээмээр байсан ч багшаасаа айгаад инээдээ арай гэж л барьж байсан сан. Энэ мэтчилэн бид одоо ч оюутан ахуй цагийн хөгжилтэй дурсамжаа сөхөн ярилцаж, инээлдэж суух дуртай. Товчхондоо төгсөөд хэдийнээ 20 жил өнгөрсөн ч бие биеэ гэсэн сэтгэлээр хамтдаа байж нэгнээ дэмжин, урам өгч улам дотносон нөхөрлөсөөр байна.

АНАГААХ УХААНЫ СУРГУУЛЬ



ЭМШУИС-ийн анхны төгсөгчид бидний нэг эд эс болж Нүүр ам судлалын чиглэлээр 25, Уламжлалт анагаах ухааны чиглэлээр 24, Эм зүйч 20, Эрүүл ахуйн, тархвар судлалын чиглэлээр 16 төгсөгч төгссөн билээ.

Анагаах ухааны сургуулийг төгссөн манайхны дунд эрдэм судлал, эмнэлзүй мэргэжлийн чиглэлээр нарийн мэргэшсэн олон сайчуул бий. Бидний дундаас 100 төгсөгч магистр, 34 төгсөгч докторын зэрэг хамгаалж, 10 хүн дэд

профессор цол хүртсэн байна. Эмнэлзүйн чиглэлээр 70 гаруй эмч мэргэжилтэн ахлах зэрэг, 50 гаруй төгсөгч тэргүүлэх зэрэг хамгаалж, 20 эмч клиникийн профессор цол хүртжээ. Жишээ дурдвал Б.Дамдиндорж, Ц.Билэгсайхан, Д.Нямдорж, С.Мөнхбаяр, Ш.Үүртуяа, Л.Энхсайхан, Б.Эрдэнэбулган, М.Мөнхбаяр нарын эрдэм судлалын сайчуул, Б.Онон, Ц.Мөнхзаяа, Ш.Орхонтуул, Д.Уранчимэг, Б.Оюунчулуун, Л.Мишигдорж, М.Зоригтбаатар, С.Нэргүй, Б.Бадамханд, С.Булгамаа, Ж.Болортуяа, Я.Дугарсүрэн, Ц.Ганзориг, А.Алтайн-Эрдэнэ, Б.Сугарсүрэн, Г.Энхбаатар, Т.Өлзийсайхан, С.Оюун-Эрдэнэ, Э.Учрал-Буян, Ш.Баярмагнай, Ж.Соёлмаа, Э.Лхагва-Очир, Ё.Мөнх-Эрдэнэ, Д.Нарантунгалаг нарын эмч хүний эрхэм чанарыг өөртөө шингээсэн алтан гартнууд, С.Хонгорзул, О.Болормаа зэрэг боловсрол судлалын мэргэжилтнүүд, Г.Очирчимэг, Г.Норовсүрэн, Д.Сэргэлэн, Б.Цогзолмаа нарын хос тангарагтай хилчин эмч нар бий. Манай курсын эмч мэргэжилтнүүд салбар салбартаа бусдыгаа манлайлан төрийн болон хувийн хэвшлийн салбарт амжилттай ажиллаж байна.

НҮҮР АМ СУДЛАЛЫН СУРГУУЛЬ

НАСС-ийн төгсөгч Н.ЦЭНДМАА:

"Бид 1998 онд ЭМШУИС-ийн Нүүр ам судлалын сургуульд элсэн орж, АУ-ын доктор, профессор, Монгол Улсын гавьяат багш Л.Мөнгөнцэцэг багшийн удирдлага дор 2003 онд 25-уулаа төгссөн. 10-р ангиа дөнгөж төгссөн, зарим нэг нь Улаанбаатар хотод орон нутгаас анх удаа ирж үзэж байгаа, нялхаараа шахуу хүүхдүүдийг гар дээрээ өлгийдөн авч 5 жил сурган хүмүүжүүлж, эмч болох замыг нь заана чиглүүлж өгсөн ухаант багш нартаа бид мянгантаа талархаад ч баршгүй.

Манай ангиас Монгол улсын Төрийн соёрхолт эмч, Ерөнхийлөгчийн нэрэмжит залуу эмчийн шагналт эмч, дэд профессор төрөн гарсан амжилтаар бид төгсөлтийнхөө

суралцан төгссөн бол ахлах зэрэгтэй дөрөв, тэргүүлэх зэрэгтэй дөрвөн эмч бид бүгдийн дундаас төрөн гарчээ.

Оюутан байхад А.Март, Х.Янжиндолгор, Б.Энхжаргал, У.Алтаннавч, М.Хосбаяр гэсэн "гавал толгойтууд" байсан ба одоо ч тэд маань эрүүл мэндийн салбарт аманлайсаар явна.

Ангийнхаа хамгийн хамгийн шалгаруулбал, хөгжилтэй, шооч нь Гэрэлмаа, Золжавхлан, нямбай нь Баасанжав, Баяржаргал, сэргэлэн нь Халиун, Оюунцэцэг, даруухан нь Баясгалан, Цэндмаа, царайлаг нь Одгэрэл, Хонгорзул, Алтанзул, Алмагүл, спортлог нь Эрдэнэцогт, Мөнхдөл, нийтэч нь Үзмээ, Болормаа тайван нь Ариунбаяр, Базаргүл



20 жилийнхээ ойг бахдалтайгаар угтаж байгаадаа баяртай байна.

Манай ангийн төгсөгчдөөс Эрдэнэцогт, Болормаа, Баяржаргал, Цэндмаа, Энхжаргал, Алдармаа, Үзмээ, Баясгалан, Алмагүл нар ЭХЭМҮТ, АШУУИС, ӨЭМТ ЭМХТ, ХСҮТ, Цэргийн төв эмнэлэг, Шүд эрүү нүүрний төв, Дархан болон Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлэг зэрэг улсын байгууллагад харин Мөнхдөл, Золжавхлан, Алтанзул, Март, Ариунбаяр, Хосбаяр, Янжиндолгор, Хонгорзул, Гэрэлмаа, Баасанжав, Одгэрэл, Алтаннавч, Халиун, Оюунцэцэг, Эрдэнэбилэг, Базаргүл нар хувийн салбарт тус тус ажиллаж байна. Эдгээрээс есөн төгсөгч нь өдгөө өөрийн хувийн эмнэлгийг байгуулан, зөвхөн эмчийн үүргийг гүйцэтгэх бус эмнэлгийн менежмент, удирдлага, санхүүжилт зэрэг ажлуудыг давхар хариуцаж, 70 орчим хүнийг ажлын байраар хангаж, улс нийгэмдээ татвар төлөгч болон эх орныхоо хөгжилд өөрсдийн хувь нэмрийг оруулсаар байна.

Одоогийн байдлаар дэд профессор нэг, АУ-ны доктор дөрөв, АУ-ны магистр найман хүн хамгаалсан ба одоо докторантурт гурван хүн суралцаж байна. Нарийн мэргэжил эзэмшсэн байдлыг авч үзвэл эрүү нүүрний мэс заслын эмч зургаа, нүүр амны согог заслын эмч тав, хүүхдийн нүүр ам судлалын чиглэлээр хоёр эмч

тусч нь Алдармаа болон ангийн дарга Эрдэнэбилэг нарыг нэрлэх байна. Оюутан ахуй дурсамжаас хуваалцавал заримдаа хичээл дээр хэсгүүдийн хооронд асуулт хариултын тэмцээн зохиогддог байлаа. Бид урьдчилгаад бэлдсэн асуулт, хариултаа солилчихихно, тэр бүү хэл чамаас энийг асууна, тэрэнд ингэж хариулаарай гээд бэлдчихээд ордог байлаа. Эргэн санахад тэр хичээлийн багш бидний энэ "нууц ажиллагааг" ядах юмгүй ойлгоод, сайхан жүжиглэж байна даа гэж бодоод дотроо инээж суудаг байсан байх гэж бодогддог. Угаас бүгдээрээ тэтгэлээ төгс мэднэ гэж юу байх вэ дээ /инээв/.

Улсын шалгалтаар манай ангийн нэг охин шүд авах талаар асуулт ирснийг ярьж байгаад "муляжны шүдийг авч" үзүүлдэг гээд ойлгочихсон, бахь суулгаад шүдийг нь авах гээд ганхуулаад байсан талаар шалгалтын дараа багш нар "муляжийг минь үлдээж үзээрэй" гээд хөгжилдөн ярьж байсан нь санагдаж байна.

Цэл залуухан оюутан ахуй цагийг минь эргүүлэн авчирч, баяр хөөрөөр баялзуулан уулзуулж байгаа ангийнхан, 2003 оны болон Алтангагнуураа тэмдэглэж байгаа нийт төгсөгчдөө баярын мэндийг хүргэж, ажил амьдралд нь хамгийн сайн сайхан бүхнийг хүсье.

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН СУРГУУЛЬ



502 хэсгийн ахлагч Д.ЦЭНДМАА

"Юуны өмнө ангиа төлөөлөн ярилцлага өгч байгаадаа баяртай байна. 2003 оны нийт төгсөгчдөө 20 жилийн ойн баярын мэнд хүргэе. Манай ангийг хэдийгээр 16-хан охин төгссөн хэдий ч өдгөө бүгд л нийгмийн салбар, салбарын нүүр царай, өнгө түүчээ нь болж явна. Манай ангиас докторант хоёр, магистр дөрөв, бизнесийн удирдлагын магистр тус тус төрөн гарчээ. Одоо бодоход их сургуулийн багш нараасаа дан ганц мэдлэг, боловсрол гэлтгүй олны дунд явах, хүнтэй харилцах арга ухаанд давхар суралцаж байж. Төлбөрөө төлөх гээд янз бүрийн ажил хийж, хажуугаар нь багшийн өгсөн хонголт 100 хуудас Орос хэлнээс орчуулах даалгавраа 20, 20-н хуудсаар нь хувааж аваад өглөө ирээд дамжуулж уншаад асуугддаг байсан оюутан цагтаа бид хайртай.

Бидний оюутан ахуй нас мартагдсан

аргагүй дурсамжтай, хөгжөөнтэй, адал явдал, баяр хөөрөөр дүүрэн байсан. Оюутан болсон анхны жилээ ангиараа урлагийн үзлэгт "дайчлагдаж" өдөр шөнөгүй бэлдэж байсан минь санаанаас гардаггүй юм.

Тэгэхэд би шүлгийн номер бэлдэж яруу найрагч агсан Бавуугийн Лхагвасүрэн гуайн "Харанхуй" шүлгийг олж унших даалгавар аваад ангиараа шахуу хүүхэлдэйн театр дээр очиж таван минут тутам тамхи татах зуур нь өөрөөр нь уншуулаад бичиж аваад цэцэглэж байсан маань одоо ч санаанаас гардаггүй. Даанч тэр их хичээл зүтгэл гаргачаад сандарсандаа шүлгээ нэг амьсгаагаар уншаад дуусчихсан заал цааш нь сонсох гээд хүлээгээд таг болчихсон, би хүмүүс алга ташихгүй болохоор яахаа мэдэхгүй зогсож байснаа гүйгээд орсон чинь заал сая нэг алгаа ташиж байрээ. Гэхдээ байр эзлээгүй ээ /инээв/.